

УЛСЫН ШАЛГАЛТ-2024

МОНГОЛ ХЭЛ V АНГИ

ДҮҮРЭГ:

СУРГУУЛЬ:

АНГИ: БҮЛЭГ:

ОВОГ:

НЭР:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- ✓ Шалгалт 60 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.
- ✓ Шалгалтын материал нь сонгох хариулт бүхий тест, задгай хэлбэрийн даалгавруудаас бүрдэнэ.
- ✓ Сонгох хариулттай даалгаврууд тус бүр 1 оноотой байна.

V АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ

2024 оны 06 дугаар сарын 05

Хугацаа 60 минут

А ХУВИЛБАР

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР:

Санамж: 1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй.

Тус

Өвгөн тэр өдөр мөн л айлуудаас сүүгээ авахаар хуучин муу машинаараа тосгон руу явж байлаа. Насаараа энэ машинаараа тосгоны айлуудаас сүү авч, зарж, амьжиргаагаа залгуулжээ. Ингээд явж байтал замын хажууд зогссон тансаг машины жолооч гар өргөн өвгөнөөс хамгийн ойр байгаа шатахуун түгээх газар руу машиныг чирээд өгөхгүй юу гэж гүйв. Өвгөн зөвшөөрч тансаг сайхан машиныг өөрийн муу машинаараа чирсээр шатахуун түгээгүүрийн газар хүргэж өгөв. Баян эр халааснаасаа хамгийн том дэвсгэрт гарган өвгөнд өгөхөд

Өвгөн: Хэрэггүй хүү минь зовсон хүнд тусалсны хариу мөнгө биш шүү дээ гээд авсангүй. Энэ явдлаас хэдэн жилийн дараа өвгөний муу машин асахаа байжээ. Өвгөний амьдрал дороо л доройтох эхлэв. Нэг өдөр тэднийд нэгэн хүн захидал авчирч өгөв.

Захидалд : Таныг нэлээд хүнд амьдралтай байгааг сонслоо. Тиймээ зовсон цагт нь хүн хүндээ туслах ёстой. Энэ хамгийн сүүлийн үеийн загварын машин, одоо таных... гээд доор нь Генри Форд гэж нэрээ таталган бичжээ. Өвгөний нүднээс нулимс бөмбөрч эхлэв...

1. Дээрх эхийн гол санааг илэрхийлсэн хэлц аль нь вэ? Яагаад энэ хэлцийг сонгосон бэ?
1 өгүүлбэрт багтаан тайлбарлан бичээрэй. /2 оноо/

A. Амьд явбал алтан аяганаас ус ууна. B. Амаа барих

C. Хүнд тус хүргэвэл өөрт тус ирнэ. D. Сайн хүнд нөхөр олон

2. Өвгөн ямар зан чанартай хүн бэ? Зөв хариултыг сонгоорой./1 оноо/

A. Ууртай B. Сайхан сэтгэлтэй C. Харамч D. Онгироо

Хариултаа батлах жишээ өгүүлбэр хоёрыг эхээс олж бичээрэй. /2 оноо/

2023-2024 оны хичээлийн жил

3. Эхээс баян эрийн хийсэн үйл, хэлсэн үгийг ялган бичээрэй. /2 оноо/

-
-
-
-

4. Эхийг зөв дараалалд оруулж дугаарласан хэсгийг сонгоорой. /1 оноо/

1. Өвгөн машиныг чирэхийг зөвшөөрөв.
2. Баян эр өвгөнд шинэ машин бэлэглэв.
3. Баян эр өвгөнд мөнгө өгөв.
4. Өвгөн тосгон руу явж байлаа.

A. 4,3,2,1 B. 2,3,1,4 C. 4,1, 3,2 D. 4,2,1,3

5. Энэ эхээс ямар сургамж авч болох тухайгаа 3 өгүүлбэрт багтаан бичээрэй. Генри Форд ямар зан чанартай вэ? /3 оноо/

-
-
-

6. Дээрх эхийг төсөөлөн үргэлжлүүлж 20-30 үгэнд багтаан дүрслэн бичээрэй. /4 оноо/

.....
.....
.....
.....
.....

2023-2024 оны хичээлийн жил

ХОЁР ЗАДГАЙ ДААЛГАВАР:

Зохион найруулан бичих чадвар

“НАДАД ТОХИОЛДСОН БАЯРТ ЯВДАЛ” сэдвээр 70-80 угэнд багтаан зохион бичнэ уу.

2023-2024 оны хичээлийн жил

УААНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ

УААНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ

2024 оны 06 дугаар сарын 05

Хугацаа 60 минут

Б ХУВИЛБАР

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР:

Санамж: 1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй.

Уучлалын салхи

Дотны хоёр найз аян замдаа явахдаа ам муруйж, нэг нь нөгөөгөө алгаджээ. Алгадуулсан найзынх нь хацар тун их өвдсөн боловч юу ч хэлэлгүй “Өнөөдөр миний хамгийн сайн найз намайг алгадлаа” гэж элсэн дээр бичив.



Цааш явсаар цөлийн дундах нэгэн баян бүрдэд ирж, усанд орж амрахаар шийджээ. Усанд орох гэтэл алгадуулсан найз нь гэнэт намагт шигдэв. Намаг түүнийг агшин зуур хүчтэй сорон доошлуулж байлаа. Үүнийг харсан найз нь үтэр түргэн ирж найзыгаа намгаас татаж гаргажээ.

Аврагдсан найз нь нэгэн том хадан дээр “Миний хамгийн сайн найз намайг аварлаа” гэж бичлээ.

Найзыгаа алгадаж, дараа нь аварсан найз нь “Намайг алгадахад элсэн дээр бичсэн атал аврахад минь яагаад хадан дээр сийлж байгаа юм бэ?” гэж асуув. Найз нь “Хэн нэгэн бидэнд муу зүйл хийхэд түүнийг сэтгэл дотроо элсэн дээр бичих хэрэгтэй. Уучлалын салхи түүнийг түүн арилгана. Харин хэн нэгэн сайн зүйл хийх юм бол чулуун дээр сийлэх хэрэгтэй. Тэгвэл ямар ч салхи хийсгэн арилгаж үл чадна хэмээн хариулжээ.

1. Дээрх эхийн гол санааг илэрхийлсэн хэлц аль нь вэ? Яагаад энэ хэлцийг сонгосон бэ? Нэг өгүүлбэрт багтаан тайлбарлан бичээрэй. /2 оноо/

A. Зүү орох зайгүй

B. Алганы амт үзүүлэх

C. Ам султай

D. Ам муруйх

2. Хүүхдүүд ямар зан чанартай вэ? Зөв хариултыг сонгоорой. /1 оноо/

A. зөрүүд

B. онгироо

C. сайхан сэтгэлтэй

D. Санаа муутай

Хариултаа батлах жишээ өгүүлбэр хоёрыг эхээс олж бичээрэй. /2 оноо/

3. Хоёр найзыг эвтэй байхыг уриалсан утгатай өгүүлбэр нэгийг бичээрэй. /2 оноо/

4. Эхийн үйл явдлыг дарааллаар нь зөв байрлуулсныг сонгоорой. /1 оноо/

1. Элсэн дээр бичив.
2. Баян бүрдэд ирэв.
3. Хоёр найз аян замд явав.
4. Найзыгаа намгаас татах гаргажээ.
5. Найзынх нь хацар тун их өвджээ.

A. 3, 5, 1, 4, 2 **B. 3, 5, 1, 2, 4** C. 3, 2, 5, 1, 4 D. 3, 2, 4, 5, 1

5. Найзууд ямар байх ёстой гэж чи боддог вэ? Тоочин бичээрэй. Алгадуулсан найз ямар зан чанартай вэ? \3 оноо \

-
-
-

6. Эхээс юуг ухаарсан бэ? Өөрийн ойлгосныг 20-30 үгэнд багтаан тайлбарлан бичээрэй. /4 оноо/

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР:

Зохион найруулан бичих чадвар

“МИНИЙ НАЙЗ” сэдвээр 70-80 үгэнд багтаан эх зохион бичээрэй.

ДААЛГАВРЫН ХАРИУ, ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Даалгаврын дугаар	Зөв хариулт	Даалгаврын оноо	Онооны тайлбар
НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР			
1	A хувилбар - С Б хувилбар - А	2	Эхэд тохирох зөв хэлцийг сонгосон бол [1] Нэг өгүүлбэрт багтаан тайлбарлан бичсэн бол [1] Эхэд тохирох зөв хэлцийг сонгоогүй бол[0] Эхэд тохирох зөв хэлцийг сонгоогүй ч өөрийн сонгосон хэлцээ зөв тайлбарласан бол [1]
2	A хувилбар - В	3	Асуултад зөв хариулсан бол [1] Эхээс хоёр жишээ өгүүлбэр бичсэн бол [2] Асуултад буруу хариулсан бол [0]
	Б хувилбар - С		Асуултад зөв хариулсан бол [1] Эхээс хоёр жишээ бичсэн бол [2] Асуултад буруу хариулсан бол [0]
3	A хувилбар	2	Эхээс баян эрийн хийсэн үйл, хэлсэн үгийг ялган бүрэн бичсэн бол [2] Баян эрийн хийсэн үйл, хэлсэн үгийн аль нэгийг бичсэн бол [1] Эхээс олж бичээгүй бол [0]
	Б хувилбар		Хоёр найзыг эвтэй байхыг уриалсан утгатай өгүүлбэр бичсэн бол [2] Хоёр найзыг эвтэй байхыг уриалсан утгатай өгүүлбэрийг бүрэн гаргаагүй бол [1] Уриалсан утгатай өгүүлбэр бичээгүй бол [0]
4	A хувилбар - С Б хувилбар – В	1	Эхийг зөв дараалалд оруулсан хэсгийг сонгосон бол [1] Эхийн үйл явдлыг зөв дараалалд оруулсан хэсгийг буруу сонгосон бол[0]
5	A хувилбар	3	Эхээс ямар сургамж авч болох тухайгаа 3 өгүүлбэрт багтаан бичсэн бол [2] Генри Форд сайхан сэтгэлтэй, тусч.... бичсэн бол [1]
	Б хувилбар		Найзууд ямар байх ёстой талаар тоочин бичсэн бол [2] Алгадуулсан найзын чанарыг бичсэн бол [1]
6	A хувилбар	4	Эхийн гол санааг алдагдуулахгүйгээр үргэлжлүүлэн бичсэн бол [1] Эхийг зөв найруулан бичсэн бол [1] Үгийн тоо гүйцэд бол [1] Зөв бичих дүрмийн алдаа гаргаагүй бол [1] Зөв бичих дүрмийн алдаа гаргасан бол (алдсан үг бүр 0,1 оноо)

	Б хувилбар		Эхээс юу ухаарсан талаар бичсэн бол [1] Өөрийн ойлгосон зүйлээ зөв найруулан бичсэн бол [1] Үгийн тоо гүйцэд бол [1] Зөв бичих дүрмийн алдаа гаргаагүй бол [1] Зөв бичих дүрмийн алдаа гаргасан бол (алдсан үг бүр 0,1 оноо)
ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР			
№	Үнэлгээний шалгуур	Авбал зохих оноо	Онооны задаргаа
1	Сэдэв ба зорилго	3	3 оноо: - Тухайн өгөгдсөн сэдвийн дагуу утгаа зөв ойлгож, зорилгоо бүрэн хангаж бичсэн тохиолдолд 2 оноо: - Бичих сэдэв, зорилгоо дутуу гаргаж бичсэн тохиолдолд 1 оноо: - Бичих сэдэв, зорилгоо хагас дутуу гаргаж бичсэн тохиолдолд 0 оноо: - Үнэлэх боломжгүй тохиолдолд X: - Юу ч бичээгүй тохиолдолд
2	Бүтэц	3	3 оноо: - Тухайн бичвэрийн бүтцийн хувьд эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй бичсэн тохиолдолд 2 оноо: - Бүтцийн аль нэг хэсгийг дутуу бичсэн тохиолдолд 1 оноо: - Бүтэц илт дутуу бичсэн тохиолдолд 0 оноо: - Үнэлэх боломжгүй тохиолдолд X: - Юу ч бичээгүй тохиолдолд
3	Үг сонголт	2	2 оноо: - Сэдвийн хүрээнд үгийг чөлөөтэй сонгож, зөв хэрэглэсэн тохиолдолд 1 оноо: - Сэдвийн хүрээнд зарим үгийг оновчгүй сонгож, үг давтаж хэрэглэсэн тохиолдолд 0 оноо: - Үнэлэх боломжгүй тохиолдолд X: - Юу ч бичээгүй тохиолдолд
4	Зөв бичих дүрмийн алдаа	5	5 оноо: - Огт алдаагүй буюу 1 алдаатай бичсэн тохиолдолд 4 оноо: - 2-4 үгийг алдаатай бичсэн тохиолдолд 3 оноо: - 5-7 үгийг алдаатай бичсэн тохиолдолд 2 оноо: - 8-10 үгийг алдаатай бичсэн тохиолдолд 1 оноо: - 11-14 үгийг алдаатай бичсэн тохиолдолд 0 оноо: - 15-аас дээш үг алдаатай бичсэн тохиолдолд X: - юу ч бичээгүй тохиолдолд
5	Бичгийн хэв	2	2 оноо: - Зөв сайхан гаргацтай, хичээнгүй бичсэн бол 1 оноо: - Зөв хичээнгүй бичээгүй ч уншиж болж байвал 0 оноо: - Үнэлэх боломжгүй тохиолдолд X: - Юу ч бичээгүй тохиолдолд
	Нийт	15	

НИЙТ 30 ОНОО

Дорнод аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар